

Эм вакцин, биобэлдмэлийн хангамж, нөөц  
чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналт

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, гишүүд “Эм, вакцин биобэлдмэлийн хангамж, нөөц, чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ”-ний талаар Эрүүл мэндийн сайд Н.Удвалын итгэлийг ажлын журмаар хэлэлцээд ЗӨВЛӨМЖ БОЛГОХ нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газарт:

1. Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа хийх, чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл, эм зүйн үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт, эмийн гаж нөлөөнд тавих хяналт, зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналтыг төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэх бие даасан эмийн эсвэл эм, хүнсний зохицуулалтын асуудал эрхэлсэн нэгдсэн агентлагийг бусад улс орны жишгийн дагуу байгуулах;

2. Эмийн түгээлтийн шат бүрд эмийн үнийг хянах механизмыг бий болгох;

3. Бүсийн төвүүдэд болон эм, эмнэлэгийн хэрэгсэл нэвтрүүлдэг хилийн боомтууд дээр эм, биобэлдмэлийн сорилын лаборатори байгуулах, шинжилгээний түргэвчилсэн арга нэвтрүүлж, хил гаалийн хяналтыг сайжруулах;

4. Цус сэлбэлт судлалын шинэ төвийн барилгыг шаардлагын хэмжээнд барих хэмжээний хөрөнгө /2,9 тэрбум төгрөг/ болон гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;

5. Үндэсний эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэлийг дэмжиж ЭМЯ-д үйлдвэрлэл хариуцсан нэгж бий болгох;

6. Биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа болон борлуулалтанд оролцохыг хориглох.